



**ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО**

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН

(2021 оны танилцуулга)

Улаанбаатар хот
2022 он

Танилцуулга хянасан:

Э.Эрдэнэсан	ҮСХ-ны Нэгдсэн статистикийн газрын дарга
С.Тодгэрэл	ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга

Танилцуулга боловсруулсан:

Н.Должинсүрэн	ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын ахлах статистикч
---------------	--

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44
Засгийн газрын III байр
Утас: (976-51)-263966, 1900-1212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: www.nso.mn, www.1212.mn
Цахим хаяг: information@nso.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
I. САРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	7
I.1 Нийгмийн даатгал төлсөн ААНБ болон ажиллагчид	7
I.2 Ажиллагчдын сарын дундаж цалин ба медиан цалин	10
I.3 Бодит цалин	20
I.4 Олон улсын харьцуулалт	22
I.5 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	24
II. ДҮГНЭЛТ	27
III. АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	29
IV. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ	35

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БЦИ	Бодит цалингийн индекс
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗЗТҮ	Хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр үзүүлэлт
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, мянган төгрөг	861.9	944.5	1 002.9	1 124.3	1 220.6	1 279.4
Эрэгтэй	913.9	1 029.4	1 100.3	1 222.6	1 326.2	1 390.1
Эмэгтэй	811.0	860.4	903.3	1 021.3	1 109.6	1 163.1
НДШ төлсөн байгууллагын тоо	40 588	41 637	43 705	45 613	46 900	49 765
НДШ төлсөн ажиллагчдын тоо	692 919	725 430	774 607	813 744	808 010	840 140
Дундаж цалин, бүс, нийслэлээр						
Баруун бүс	607.5	626.3	647.7	764.0	878.3	911.5
Хангайн бүс	763.8	767.8	828.4	967.9	1 104.0	1 157.3
Төвийн бүс	712.9	774.5	829.1	960.5	1 088.7	1 158.7
Зүүн бүс	663.0	705.6	728.2	856.7	987.0	1 042.3
Улаанбаатар	953.4	1 062.4	1 119.7	1 232.2	1 312.6	1 370.6
Дундаж цалин, ажиллагчдын тооны бүлгээр						
1-9 ажиллагчидтай байгууллагынх	599.9	628.2	646.8	730.6	827.5	861.2
10-49 ажиллагчидтай байгууллагынх	702.8	743.9	761.5	872.9	967.4	1 044.5
50-99 ажиллагчидтай байгууллагынх	788.1	851.9	891.8	977.2	1 076.6	1 135.7
100-99 ажиллагчидтай байгууллагынх	916.4	923.6	993.4	1 079.5	1 227.6	1 279.4
200, түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх	1 131.5	1 295.8	1 387.4	1 556.9	1 660.3	1 713.0
Дундаж цалин, ажил мэргэжлийн ангиллаар						
Менежер	1 010.0	1 073.9	1 097.8	1 201.0	1 366.8	1 385.8
Мэргэжилтэн	967.1	1 053.7	1 138.2	1 344.9	1 391.8	1 480.2
Техникч болон туслах /дэд мэргэжилтэн	967.1	1 083.1	1 193.6	1 350.8	1 470.6	1 541.7
Контор, үйлчилгээний ажилтан	803.2	915.9	967.9	1 099.2	1 235.4	1 298.1
Худалдаа, үйлчилгээний ажилтан	595.8	671.8	693.5	776.6	864.6	913.7
ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	453.5	511.7	518.1	633.9	701.3	752.5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	845.6	928.3	989.5	1 250.7	1 257.1	1 329.8
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	1 060.1	1 150.4	1 191.1	1 296.9	1 419.8	1 493.2
Энгийн ажил мэргэжил	678.7	661.3	714.2	821.9	939.8	997.5
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	824.7	997.1	1 056.7	1 234.6	1 327.9	1 359.5
Дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр						
Хувьцаат компани	969.6	1 090.9	1 150.8	1 258.2	1 382.8	1 421.9
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	927.7	1 045.8	1 110.2	1 216.6	1 279.8	1 338.9
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	644.1	679.3	702.9	803.6	1 034.1	1 372.5
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	767.3	738.6	523.6	609.9	794.3	955.3
Хоршоо	392.4	462.0	483.7	577.2	654.6	666.7
Төрийн өмчит үйлдвэрийн газар	1 033.1	1 118.3	1 211.1	1 352.7	1 546.5	1 679.3
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	674.4	697.5	752.4	851.0	960.6	999.6
Төсөвт байгууллага	731.5	743.0	772.8	917.2	1 053.4	1 099.4
Төрийн бус байгууллага	706.6	755.6	794.1	888.9	999.4	1 075.0



АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, 2021 онд

Эмэгтэй
1 163.6
мянган төгрөг




Улсын дундаж
1 279.4
мянган төгрөг



Эрэгтэй
1 390.1
мянган төгрөг

Цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Ажиллагчид



АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН


I. САРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

I.1 Нийгмийн даатгал төлсөн аж ахуйн нэгж, байгууллага болон ажиллагчид

ҮСХ-ны бизнес регистрийн мэдээллийн санд 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 96.3 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна. Тэдгээр аж ахуйн нэгж, байгууллагаас Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо 46.6 мянгаар бага байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаа явуулж буй нийт байгууллагын 51.7 хувийг эзэлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2021 оны тайланд 49.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 840.1 мянган ажиллагчид хамрагдсан байна. Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлж буй аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын тоо 2014 оноос 17.7 (55.3%) мянгаар, өмнөх оноос 2.9 (6.1%) мянгаар тус тус өсжээ.

Зураг 1. НДШ төлөлтийн тайланд хамрагдсан ААНБ-ын тоо, 2014-2021 он



Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан ажиллагчид/даатгуулагчдын тоо 2021 онд 2014 оноос 265.7 (46.3%) мянгаар, өмнөх оноос 32.1 (4.0%) мянгаар нэмэгджээ.

Нийт ажиллагчдын 430.5 (51.2%) мянга нь эрэгтэйчүүд, 409.6 (48.8%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 2. НДШ төлөлтийн тайланд хамрагдсан ажиллагчдын тоо, өөрчлөлтийн хувь, 2014-2021 он



Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт ажиллагчдыг байршлаар нь авч үзвэл 275.9 (32.8%) мянга нь орон нутгийн, 564.2 (67.2%) мянга нь нийслэлийн ажиллагчид байв.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2021 онд хамрагдсан нийт даатгуулагчдын 119.4 (14.2%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 119.3 (14.2%) мянга нь боловсролын салбарын, 92.4 (11.0%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын, 90.0 (10.7%) мянга нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын, 56.0 (6.7%) мянга нь барилгын салбарын, 51.9 (6.2%) мянга нь тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын, 51.3 (6.1%) мянга нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний салбарын, 45.3 (5.4%) мянга нь уул уурхай, олборлолтын салбарын, 32.6 (3.9%) мянга нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын, 31.1 (3.7%) мянга нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчид байгаа бол үлдсэн 17.9 хувийг бусад салбарын ажиллагчид эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан даатгуулагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2018-2021


Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2018	2019	2020	2021
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21 016	20 639	21 571	21 631
Уул уурхай, олборлолт	44 723	46 963	44 087	45 253
Боловсруулах үйлдвэрлэл	85 461	89 156	88 879	92 372
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	13 945	14 340	14 326	15 332
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	9 757	9 463	9 577	10 135
Барилга	53 310	57 013	57 698	55 985
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	97 988	107 959	107 441	119 356
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	39 703	47 393	47 911	51 942
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	23 014	23 165	19 307	19 498
Мэдээлэл, холбоо	16 469	17 064	17 633	19 643
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	31 983	32 604	31 570	32 600
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2 831	2 965	3 251	3 648
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон технологийн үйл ажиллагаа	23 851	24 414	24 508	25 948
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	29 937	31 506	30 595	31 136
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	83 546	86 566	87 359	90 250
Боловсрол	113 383	117 381	117 115	119 344
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	46 738	48 502	48 920	51 280
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10 180	9 841	9 575	9 528
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	24 259	24 245	23 418	22 119
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	411	550	563	772
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 102	2 015	2 706	2 368
БҮГД	774 607	813 744	808 010	840 140

Нийт даатгуулагчдын 2021 оны тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар 2019 болон 2020 онтой харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн салбар, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар болон хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний салбарт ажиллагчид хамгийн ихээр буюу 2.4-11.9 мянгаар нэмэгджээ. Харин барилгын болон үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ажиллагчид 1.0-2.1 мянгаар буурсан байна.

1.2 Ажиллагчдын сарын дундаж цалин ба медиан цалин

ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин 2010-2021 онд тогтмол өссөн бөгөөд нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2021 оны байдлаар 1.3 сая төгрөг болж, 2010 оноос 3.7 дахин, 2015 оноос 471.4 (58.3%) мянган төгрөгөөр, өмнөх оноос 58.8 (4.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 3. Ажиллагчдын сарын дундаж цалин, мянган төгрөгөөр



Тайлбар:


ҮСХ нь ажиллагчдын сарын дундаж цалин хөлсний мэдээллийг 2000-2013 онд ААНБ-д суурилсан түүвэр судалгааны үр дүнгээр тооцож байсан. Харин 2014 оноос эхлэн мэдээллийн эх үүсвэрийг өөрчилж, НДЕГ-ын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн тооцож байна.

Медиан цалин нь НДЕГ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тухайн улирал/жилд хамрагдсан нийт ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр жагсаахад түүний төв буюу хоёр талыг тэнцүү хэсэгт хувааж буй ажилтны цалингаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, медиан цалин гэдэг нь нийт цалинтай ажиллагчдын авч буй голч цалингийн хэмжээ юм.

НДЕГ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт ажиллагчдын медиан цалингийн хэмжээ 2021 онд 951.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 50.7 (5.6%) мянган төгрөгөөр өссөн байна.

ААНБ-ын ажиллагчдын медиан цалин нь улсын дундаж цалингаас 328.0 (25.6%) мянган төгрөгөөр бага байна. Дундаж цалин болон медиан цалингийн харьцаа 2020 оны 4 дүгээр улиралд 2015 оны 4 дүгээр улирлаас 3.4 нэгж хувиар, харин 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 4.1 нэгж хувиар холдсон нь ажиллагчдын цалингийн ялгаа ихэссээр байгааг харуулж байна.

Зураг 4. Ажиллагчдын сарын дундаж цалин болон медиан цалин, улирлаар, мянган төгрөгөөр



Дундаж цалингийн өөрчлөлтөд дараах шийдвэрүүд нөлөөлжээ. Тухайлбал:

Хүснэгт 2. Засгийн газрын тогтоол

- Цалин хөлсийг тогтмол нэмэгдүүлснээс гадна урамшууллын тогтолцоог боловсронгуй болгосон. 2017 онд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчдад 300 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

Баталсан огноо	Засгийн газрын тогтоолын дугаар	Нэмэгдүүлсэн огноо
2018.08.22	264	2018.09.01
2019.01.16	24	2019.01.01
2019.12.25	472	2020.01.01

- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн үйлчилгээний албан хаагчдад өмнө нь олгогддоггүй байсан удаан жилийн нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс шинээр олгож эхэлсэн. Ингэснээр 5%-25%-ийн нэмэгдлийг авч эхэлсэн. Энэ нь ялангуяа багш, эмч нарын орлогыг нэмэгдүүлэх талаар Засгийн газраас авч буй томоохон арга хэмжээ юм.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны тогтоолын дагуу дараах байдлаар нэмэгдүүлсэн.

Хүснэгт 3. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн байдал


Огноо	Тогтоолын дугаар	Нэмэгдүүлсэн хувь	Тогтоосон доод хэмжээ (төгрөг)	Мөрдөж эхэлсэн хугацаа
2013.04.11	07	36.8%	192 000	2014.01.01
2016.04.20	04	25.0%	240 000	2017.01.01
2018.08.19	05	33.3%	320 000	2019.01.01
		31.3%	420 000	2020.01.01
2022.05.04	10	31.0%	550 000	2023.01.01

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2022 оны 5 дугаар сард 550.0 мянган төгрөг болгон тогтоосон ч уг тогтоолыг 2023 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөх юм.

- Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоол, 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол, 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолоор тус тус Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэн.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдын сарын дундаж цалингаас илүү байх хандлага хадгалагдсаар байна.

Зураг 5. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мян.төг, 2010-2021 он



Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдынхаас 2021 онд 227.0 (19.5%) мянган төгрөгөөр их байна. Эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн зөрүүг өмнөх онтой харьцуулахад 10.4 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Монгол Улс нь тэгш шан хөлс олгох тухай НҮБ-ын 100 дугаар конвенц (1969)-д нэгдэн орсон орны нэг бөгөөд Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно хэмээн заасан.


Монгол Улсын эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 83.7 хувь байгаа нь дэлхий дунджаас дээгүүр боловч 2015 онтой харьцуулахад 5.2 нэгж хувиар буурсан байна. Харин өмнөх онтой харьцуулахад ижил түвшинд байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2021 онд хамрагдсан нийт ажиллагчдын 96.4 (11.5%) мянга нь 420000 төгрөг хүртэлх цалинтай, 176.7 (21.0%) мянга нь 420001-700000 төгрөгийн цалинтай, 119.2 (14.2%) мянга нь 700001-900000 төгрөгийн цалинтай, 190.8 (22.7%) мянга нь 900001-1300000 төгрөгийн цалинтай, 63.7 (7.6%) мянга нь 1300001-1500000 төгрөгийн цалинтай, 88.3 (10.5%) мянга нь 1500001-2000000 төгрөгийн цалинтай, 40.5 (4.8%) мянга нь 2000001-

2500000 төгрөгийн цалинтай, 64.5 (7.7%) мянга нь 2500001 төгрөгөөс дээш цалинтай байна.


Ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр, өмнөх онтой харьцуулж үзэхэд 700.0 мянга хүртэлх төгрөгийн цалинтай ажиллагчдын тоо 11.6 мянгаар буурсан бол 900.0-1500.0 мянган төгрөгийн цалинтай ажиллагчид 10.7 мянгаар, 2.0 сая төгрөгөөс дээш цалинтай ажиллагчид 19.4 мянгаар тус тус нэмэгдсэн байна. 900001 төгрөгөөс дээш цалинтай ажиллагчдын эзлэх хувь 2014 оноос хойш тасралтгүй нэмэгдсэн байна.

Зураг 6. ААНБ-ын ажиллагчид, цалин хөлсний бүлгээр, мянган хүн, дүнд эзлэх хувь, 2020-2021 он



Ажиллагчдын сарын дундаж цалинг аймаг, нийслэлээр авч үзвэл, 2021 онд Орхон аймагт ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 444.0 (34.7%) мянган төгрөгөөр их байгаа бол бусад аймгийн ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 8.5-427.6 (0.7%-33.4%) мянган төгрөгөөр бага байна.


Зураг 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, мянган төгрөг, аймаг, нийслэлээр



ААНБ-ын хэмжээнээс хамаарч ажиллагчдын дундаж цалин ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, ажиллагчдын тоо их байх тусам дундаж цалин нэмэгдэж байгааг зургаас харж болно.

ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр харьцуулбал 1-9, 10-49, 50-99 ажиллагчтай ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 143.7-418.3 (11.2%-32.7%) мянган төгрөгөөр бага байгаа бол 100-199 ажиллагчтай байгууллагын дундаж цалин улсын дундаж цалинтай адил байна. Харин 200, түүнээс дээш ажиллагчтай ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 433.5 (33.9%) мянган төгрөгөөр их байна.


Зураг 8. Ажиллагчдын сарын дундаж цалин, ААНБ-ын ажиллагчдын тооны бүлгээр, мянган төгрөгөөр



Ажиллагчдын сарын дундаж цалинг байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдын сарын дундаж цалин 1.7 сая төгрөг, хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.4 сая төгрөг,

хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.3 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 59.5-399.8 (4.7%-31.3%) мянган төгрөгөөр их байна.

Зураг 9. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, мянган төгрөгөөр




Харин хоршоонд ажиллагчдын цалин 666.7 мянган төгрөг, зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөлийнх 955.3 мянган төгрөг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдынх 999.6 мянган төгрөг, төрийн бус байгууллагад ажиллагчдынх 1075.0 мянган төгрөг, төсөвт байгууллагад ажиллагчдынх 1099.4 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 180.0-612.7 (14.1%-47.9%) мянган төгрөгөөр бага байна.

Үүнээс харахад хязгаарлагдмал хариуцлагатай компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, бусад (хувийн цэцэрлэг, сургууль гэх мэт) болон хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж улсын дунджаас харьцангуй өндөр байна.

Түүнчлэн дундаж цалинг өмнөх онтой харьцуулахад төрийн өмчит үйлдвэрийн газар, нөхөрлөл болон хувийн цэцэрлэг, сургуулийн ажиллагчдын цалин хамгийн их буюу 80.0-338.4 мянган төгрөгөөр нэмэгджээ.


Төсөвт байгууллагад ажиллагчдын тоо 2021 онд 209.2 мянга байгаа нь нийт НДШ төлсөн ажиллагчдын 24.9 хувийг эзэлж байна. Төсөвт байгууллагад ажиллагчдын тоо өмнөх оноос 5.1 (2.5%), 2016 оноос 17.2 (8.9%) мянгаар нэмэгджээ.

Зураг 10. НДШ төлсөн төсөвт байгууллагын ажиллагчдын тоо, өсөлтийн хувь



Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн их байгаа бөгөөд 2021 оны байдлаар 3.0 сая төгрөг, харин зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллагчдын дундаж цалин хамгийн бага буюу 801.7 мянган төгрөг байна. Түүнчлэн тээвэр, агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл, холбоо, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалт, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын сарын дундаж цалин улсын дундаж цалингаас 7.6-714.7 мянган төгрөгөөр их байгаа бол бусад салбарын хувьд улсын дундаж цалингаас 1.9-477.7 мянган төгрөгөөр бага байна.

Зураг 11. Ажиллагчдын сарын дундаж цалин, ЭЗБТҮАС-ын ангиллаар, мянган төгрөгөөр



Түүнчлэн салбарын ангиллаар 2016 онтой харьцуулахад хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын дундаж цалин бусад салбаруудтай харьцуулахад хамгийн их буюу 85.9 хувиар өссөн бол тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн бага буюу 30.7 хувь өсжээ. Мөн түүнчлэн хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний салбарт ажиллагчдын сарын дундаж цалин 2016 оноос 72.7 хувь, боловсролын салбарынх 46.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Ажиллагчдын сарын дундаж цалингийн өсөлтийн хувь, ЭЗБТҮАС-ын ангиллаар (өмнөх онтой харьцуулсан өсөлт)

Салбар	2017 2016	2018 2017	2019 2018	2020 2019	2021 2020
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	103.7	104.3	117.5	117.8	115.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	106.0	113.2	118.8	113.4	115.0
Мэдээлэл, холбоо	105.8	113.1	111.0	110.1	110.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	105.3	106.2	111.3	105.6	109.8
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	123.2	86.5	120.1	102.5	109.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	103.7	107.8	112.5	111.9	107.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	111.3	109.1	120.1	108.9	107.2
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	103.8	102.4	106.7	107.7	106.9
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	106.8	103.2	110.5	110.7	106.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	107.9	108.1	113.1	114.0	105.6
Боловсруулах үйлдвэрлэл	122.7	105.8	101.8	99.4	105.5
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	106.7	107.9	114.7	106.1	104.3
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	104.8	107.2	114.2	117.7	104.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	104.6	102.6	115.7	108.2	104.3
Уул уурхай, олборлолт	106.5	104.8	116.6	111.1	104.2
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	103.0	103.1	118.2	114.3	103.5
Боловсрол	101.1	105.5	118.8	112.1	103.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	110.0	105.2	103.5	107.4	102.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	106.7	117.5	117.1	115.1	101.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	123.9	98.5	102.2	104.3	101.0
Барилга	116.8	121.2	112.5	109.6	96.3

Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил, мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 2021 онд техникч болон туслах/дэд мэргэжилтний сарын дундаж цалин хамгийн их буюу 1.5 сая төгрөг, харин ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтных 752.5 мянган төгрөг буюу хамгийн бага байна.

Өмнөх онтой харьцуулахад мэргэжилтний цалин 88.4 (6.4%) мянган төгрөгөөр буюу хамгийн их өссөн бол менежерийн цалин 19.0 (1.4%) мянган төгрөгөөр өссөн хамгийн бага өсөлттэй байна.

Зураг 12. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажил мэргэжлийн ангиллаар, мянган төгрөгөөр



1.3 Бодит цалин

Бодит цалин нь нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.


Бодит цалингийн индекс

Бодит цалингийн индекс (БЦИ) нь ажиллагчдын орлогын ерөнхий түвшний өөрчлөлтийг харуулах үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтийг нийгэм, эдийн засгийн бодлогын хяналт, хэрэгжилт, ялангуяа хөдөлмөрийн нөөцийн талаар бодлого

төлөвлөлт, ашиглалт, цалингийн хэмжээг тогтоох, нийгмийн даатгал, хөдөлмөрийн зардал зэрэг хөдөлмөр эрхлэлтийн холбогдох асуудлыг тодорхойлох, боловсруулахад суурь мэдээлэл болгон ашиглана.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хэрэглээний үнийн индексээр засварлаж тооцвол ажиллагчдын бодит цалин 2021 онд 956.2 мянган төгрөг болж байна. Өөрөөр хэлбэл ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн цалинг суурь онтой харьцуулахад 2021 онд 58.3 хувиар өссөн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлсэн бодит цалингийн индекс 18.3 хувиар нэмэгджээ.

Зураг 13. Бодит цалингийн индекс (2015=100), жилээр, хувиар



БЦИ нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас зөвлөмж болгосон хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр 17 үзүүлэлтийн нэг бөгөөд тухайн үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэсэн ажил, орлогын түвшнийг илэрхийлж, ажиллагчдын худалдан авах чадварыг харуулах гол үзүүлэлт юм. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар бодит цалингийн индекс өмнөх оноос 2.6 нэгж хувиар буурчээ.


Хүснэгт 5. Бодит цалингийн индекс, 2015=100, хувиар, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2016	2017	2018	2019	2020	2021
Улсын дундаж	105.9	111.2	110.6	115.5	120.9	118.3
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	97.4	100.7	101.9	107.4	118.1	116.4
Уул уурхай, олборлолт	104.2	106.4	104.4	113.5	121.5	118.2
Боловсруулах үйлдвэрлэл	114.3	134.5	133.1	126.3	121.0	119.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	105.9	111.6	109.9	106.0	109.7	105.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх Барилга	101.1	101.6	102.0	108.6	123.2	120.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	109.3	122.4	138.8	145.6	153.9	138.4
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	106.0	108.5	104.9	108.0	115.3	114.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	110.5	110.0	105.4	104.8	108.9	108.7
Мэдээлэл, холбоо	104.4	105.5	104.9	108.8	110.8	113.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	101.7	103.2	109.2	113.0	120.0	123.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	102.4	102.6	98.5	106.2	110.9	107.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	99.8	102.1	112.4	122.6	136.1	129.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	109.9	130.5	120.4	114.6	115.3	108.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	102.4	109.2	111.6	124.8	131.1	131.2
Боловсрол	98.2	100.4	101.4	108.4	110.9	108.1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	96.2	93.3	92.1	102.0	110.3	106.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	94.6	94.0	91.8	100.6	114.3	123.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	94.1	92.9	89.7	98.9	109.0	105.3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	99.6	99.0	99.9	104.7	113.0	113.7
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	99.2	100.8	106.8	118.2	129.3	138.9
	94.3	111.4	90.3	101.1	99.9	102.0

1.4 Олон улсын харьцуулалт

Монгол Улсын сарын дундаж цалинг ам.долларт шилжүүлж тооцоход 2020 онд 429 ам.доллар байсан бол 2021 онд 418 ам.доллар болжээ. Энэ үзүүлэлтийг хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-ын ажиллагчдын сарын дундаж цалинтай харьцуулахад БНХАУ-ын ажиллагчдын дундаж цалин 1251 ам.доллар, ОХУ-ын ажиллагчдын дундаж цалин 706 ам.доллар байгаа нь манай улсынхаас 1.7 болон 3.0 дахин их байна.

Зураг 14. Хөрш орнуудын сарын дундаж цалингийн харьцуулалт, ам.доллаароор




Эх үүсвэр: www.tradingeconomics.com

Дэлхийн Банкны шинэ ангиллаар Монгол Улс “дундаас доош орлоготой” улс орнуудын жагсаалтад орох болсон. Энэхүү шинэчлэлтээр “extreme poverty” буюу “хэт ядуу” хэмээх түвшнийг шинэчилж, “дунд орлоготой” орнуудын ядуурлын босгыг “дундаас дээш” ба “дундаас доош” гэж хоёр хуваан, “өндөр орлоготой” орнуудын ядуурлаас гарах босгыг өндөрсгөсөн байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг дундаас доош орлоготой бусад орнуудын сарын дундаж цалинтай харьцуулбал манай улсын дундаж цалин харьцангуй дээгүүр байгаа юм.

Зураг 15. Сарын дундаж цалин хөлс, Дэлхийн банкнаас тодорхойлсон дундаас доош орлоготой зарим улсаар, ам.доллар, 2021 он




Эх үүсвэр: www.tradingeconomics.com

Ази, Номхон далайн бүсийн улс орнуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний дундаж утга нь 381 доллар (PPP) байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 48 доллароос (Бангладеш улсад) 2166 доллар (Австрали улс) байна. Япон, БНСУ, Шинэ

Зеланд, Австрали зэрэг өндөр хөгжилтэй улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хамгийн их байдаг бол Бангладеш улсад хамгийн бага байна. Харин Монгол Улсын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2019 онд 120 доллар байгаа нь Ази, Номхон далайн бүсийн орнуудын дунджаас 3.2 дахин бага байна.

Зураг 16. Ази, Номхон далайн бүсийн улс орнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, 2019 он (ам.доллар болон ХАЧП-аар)



XXДХ = Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ. ХАЧП = Худалдан авах чадварын паритет

Эх үүсвэр: Global wage report 2020-21

1.5 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын тодорхойлсноор “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ” нь цалин хөлсний хуваарилалтын хамгийн доод хэсэгт байгаа ажилчдыг хамгаалах зорилгоор тогтоосон цалингийн бүтцийн суурь давхаргын хамгийн бага хэмжээ юм.

ОУХБ-ын 135 дугаар зөвлөмжид “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (ХХДХ)-г тогтоох нь төрөөс ядууралтай тэмцэх нэг хэрэгсэл болж, бүх ажиллагчдын болон тэдний гэр бүлийн хэрэгцээг хангах ёстой бөгөөд энэхүү хэмжээг тогтоох гол зорилго нь нийгмийн хамгаалал зайлшгүй шаардлагатай байгаа хамгийн бага цалин хөлсөөр ажиллагчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоож олгох явдал” гэж заасан байна. Зөвлөмжид мөн ХХДХ-г тогтооход ажиллагчийн болон түүний гэр бүлийн хэрэгцээ, дундаж цалин, нийгмийн хамгааллын тэтгэмжийн хэмжээ, амьжиргааны өртгийн өөрчлөлт, бусад нийгмийн бүлгүүдтэй харьцуулсан түвшин болон эдийн засгийн хүчин зүйлүүд болох эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин зэргийг харгалзан үзэхийг зөвлөсөн байдаг.


Монгол Улсын “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль”-д “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажиллагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар юм” гэж тодорхойлсон байдаг. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дараах хүчин зүйлийг харгалзан тогтоох буюу өөрчилнө гэж заажээ. Үүнд:

- Хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт
- Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа
- Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ
- Эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин

Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1998 оноос хойш 2-3 жил тутам нэмэгдүүлж ирсэн бөгөөд өсөлтийн хувь хэмжээ ялгаатай байсан. Тухайлбал, 1998-2000 онуудад 106.0 хувиар огцом нэмэгдүүлж байсан бол 2006-2007 онуудад 69.8 хувиар нэмэгдүүлжээ. Харин бусад онуудад 6.3-36.8 хувиар нэмэгдүүлж ирсэн байна.

Өмнө дурдсаны дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны хурлын 2018 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоолоор “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ”-г 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 320000 төгрөг, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 420000 төгрөг, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 550000 төгрөг байхаар шинэчлэн тогтоож, 2020 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өмнөхөөс 31.3 хувиар, 2022 онд 31.0 хувиар нэмэгдүүлсэн.

Зураг 17. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, батлагдсан оноор, мянган төгрөгөөр



Эх үүсвэр: Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс бага цалинтай ажиллагчид

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх нь зөвхөн цалингийн доод хэмжээгээр цалин хөлс авч байгаа ажилтнуудад хамаатай юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2021 онд нийт 840.1 мянган ажиллагчид нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эдгээр ажиллагчдын 96.4 (11.5%) мянга нь 420.0 мянган төгрөг хүртэлх буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур цалин авчээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур хэмжээний цалин хөлс авсан ажиллагчдын эзлэх хувь 2015 оныхоос 6.0 нэгж хувиар өссөн бол өмнөх оноос 0.4 нэгж хувиар буурсан байна.

Зураг 18. Нийт ажиллагчид, ХХДХ-ээр цалинжиж буй ажиллагчид болон тэдгээрийн нийт ажиллагчдад эзлэх хувь



Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тухайн онд хамрагдсан нийт ажиллагчид болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байгаа ажиллагчдын тоог харьцуулж үзэхэд, нийт ажиллагчдад, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байгаа ажиллагчдын эзлэх хувь 2014 онд 6.3 хувь байна. Цаашид энэ хувь буурч 2016 онд 5.2 хувь болжээ. Харин 2017 онд өсөж 8.0 хувь болж өссөөр 2021 онд 11.5 хувь болсон байна.

II. ДҮГНЭЛТ

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдаж буй ААНБ болон ажиллагчдын тоо жил ирэх тусам өссөөр байгаа бөгөөд 2021 онд 49.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 840.1 мянган ажиллагчид хамрагдсан байгаа нь 2014 оноос ААНБ-ын тоо 17.7 (55.3%) мянгаар, өмнөх оноос 2.9 (6.1%) мянгаар, ажиллагчид/даатгуулагчдын тоо 2014 оноос 265.7 (46.3%) мянгаар, өмнөх оноос 32.1 (4.0%) мянгаар тус тус нэмэгджээ.
- Ажиллагчдын сарын дундаж цалинг байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдын сарын дундаж цалин 1.7 сая төгрөг, хувьцаат компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.4 сая төгрөг, хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллагчдын сарын дундаж цалин 1.3 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 59.5-399.8 (4.7%-31.3%) мянган төгрөгөөр их байна.
- Ажиллагчдын сарын дундаж цалин эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар ялгаатай байгаа бөгөөд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн их байна. Энэ үзүүлэлт 2021 оны байдлаар 3.0 сая төгрөг, харин зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн бага буюу 801.7 мянган төгрөг байна.
- Ажиллагчдын сарын дундаж цалинг ажил, мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 2021 онд техникч болон туслах/дэд мэргэжилтний сарын дундаж цалин хамгийн их буюу 1.5 сая төгрөг, харин ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтных 752.5 мянган төгрөг буюу хамгийн бага байна.
- Улаанбаатар хотод ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 91.3 (7.1%) мянган төгрөгөөр, Орхон аймагт ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 444.0 (34.7%) мянган төгрөгөөр тус тус их байна. Бусад аймгийн ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 8.5-427.3 (0.7%-33.4%) мянган төгрөгөөр бага байна.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлж буй аж ахуйн нэгж, байгууллагыг ажиллагчдын тоогоор ялгаатай таван бүлэгт ангилж, бүлэг бүрийн хувьд ажиллагчдын сарын дундаж цалинг тооцоход ажиллагчдын тоо нэмэгдэх тутам сарын дундаж цалин хөлсний хэмжээ өссөн байна.
- Ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн цалинг суурь онтой харьцуулахад 2021 онд 58.3 хувиар өссөн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлсэн бодит цалингийн индекс 18.3 хувиар нэмэгджээ.

- Ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр, өмнөх онтой харьцуулж үзэхэд 900001 төгрөгөөс дээш цалинтай ажиллагчдын эзлэх хувь 2014 оноос хойш тасралтгүй нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2021 онд хамрагдсан 840.1 мянган ажиллагчдын 11.5 хувь нь 420.0 мянган төгрөг хүртэлх буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс доогуур хэмжээний цалин авчээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалинтай ажиллагчдын дүнд эзлэх хувь сүүлийн жилүүдэд өссөн хэдий ч 2021 онд өмнөх онтой харьцуулахад 0.4 нэгж хувиар буурчээ.
- Цаашид ҮСХ-ноос НДЕГ-ын сангийн мэдээллийг нууцлалыг хангасан байдлаар ашиглан, гүнзгийрүүлсэн судалгаа хийж, мэдээллийг тархаах, цалин хөлсний бүтэц, ажил эрхлэлтийн зардлын үзүүлэлтийг түүвэр судалгаагаар тогтмол цуглуулан, судлах нь зайлшгүй шаардлага байна.
- Мөн түүнчлэн ҮСХ-ноос холбогдох байгууллагуудтай хамтран мэдээллийн анхан шатны нэгжид ангилал, кодын үнэн бодит байдалд хяналт хийж, мэдээллийн үзүүлэлтүүдийг дэлгэрүүлэн боловсруулах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

III. АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ: Үндэсний Статистикийн хороо нь Монгол Улсад албан ёсоор ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэний дундаж орлого, цалин болон холбогдох бусад үзүүлэлтүүдийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн тооцож, үр дүнг улирал, жилээр тархааж байна.

Дундаж цалингийн статистикийн мэдээллийг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн нэгдсэн аргачлалаар тодорхойлдог. ҮСХ нь дараах үндсэн аргачлал, ангилал, кодыг ашиглаж ажиллагчдын цалин хөлсний үзүүлэлтийг хэмжиж, задалж тооцож байна. Үүнд:

- ҮСХ-ны даргын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/173 тоот тушаалаар батлагдсан “Бодит цалингийн индексийг тооцох аргачлал”
- ҮСХ-ны даргын 2012 оны 08 дугаар сарын 14-ний 1/96 тоот тушаалаар батлагдсан “Ажил эрхлэлтийн зардлын индекс тооцох аргачлал”
- Монгол Улсын Засаг захиргааны нэгжийн ангилал, код
- Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ISCO-08)
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)
- Байгууллагын хариуцлагын хэлбэр
- Байгууллагын өмчийн хэлбэр

ЦАЛИН ХӨЛС: Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллаагүй цагийн олговор болон бусад олговроос бүрдэх бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар суутгагдаагүй дүн юм. Жишээ нь: Иргэн Ц-гийн нэрлэсэн цалин нь 1279433 төгрөг гэж үзээд, гарт олгох цалинг зургаар харуулбал 1035068 төгрөг байна.



Ажиллагчдын сарын дундаж цалин, хөлсний мэдээлэл нь Монгол Улсын хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдаж буй ААНБ-ын ажиллагчдын хүрээгээр тодорхойлогдоно. НДЕГ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд улирал, жил тутамд нийт 46.0-49.0 мянган ААНБ-ын 700-800 орчим мянган ажиллагчид хамрагдаж байна. Харин үйл ажиллагаа нь түр болон бүрэн зогссон, татан буугдсан зэрэг идэвхгүй байгаа ААНБ хамрагдахгүй мөн сайн дураар даатгуулагчдын мэдээлэл хамаардаггүй болно.

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого: Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор, Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс, ААНБ-аас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлогыг багтаана (НДТХ-ийн 32 дугаар зүйл).

Цалин хөлс: Үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ (Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйл 101.1 дэх заалт).

Үндсэн цалин: Ажиллагчдад олгосон цалин, хөлс байна. Энд бүтэн цагаар ажиллагчдын үндсэн цалин, бүрэн болон бүрэн бус цагаар ажиллагчдын хөдөлмөрийн хөлс орно.

Нэмэгдэл: Ажилтны үр чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.

Нэмэгдэл хөлс: Ажлын үр дүнгээр олгож буй нэмэгдэл хөлс, үндсэн ажлынхаа зэрэгцээ бусад мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласны, эзгүй байгаа ажилтны үүргийг гүйцэтгэсэн ажлын, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн ажлын, нийтээр амрах болон баяр ёслолын өдөр ажилласны, илүү цагаар болон, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс орно.

Шагнал урамшуулал: Улирал, жилийн эцсийн ажлын үр дүнгээр болон онцгой чухал буюу онц албан даалгавар биелүүлсний төлөө олгох мөнгөн урамшуулал, ашиг хуваарилалтын шагнал, амралт болон шагнал урамшуулалтай холбоотой бусад нэмэгдэл төлбөрүүд, олгосон эд зүйл болон үнэ бүхий зүйлийн шагнал, урамшуулал орно.

Ажиллаагүй цагийн олговор: Ээлжийн амралтын олговор, цалинтай чөлөө, сул зогсолтын үеийн олговор гэх мэт орно.

Хууль тогтоомжид заасан бусад олговор: Монгол Улсын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу олгох бусад олговор орно.

Дундаж цалин гэдэг нь тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Тодорхой хэмжээний цалин хөлсийг хэд хэдэн ажиллагчид авдаг, өөрөөр хэлбэл цалин хөлсний хэмжээ давтагдаж байдаг учраас ажиллагчдын сарын дундаж цалин хөлс нь тайлант хугацаан дахь нийт цалингийн хэмжээг тухайн хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоонд жигнэж тооцсон үзүүлэлт юм.

$$\bar{x} = \frac{\sum_{i=1}^n (w_i * x_i)}{\sum_{i=1}^n w_i}$$

\bar{x} – Дундаж цалин хөлс

x_i – Ажиллагчдын нийт цалин хөлс

w_i – Ажиллагчдын тоо

Медиан цалин: Ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм.



Ажиллагчдын тоо тэгш бол:
цалин

M_e – Цувааны төвд орших ажилтны

n – Нийт ажиллагчдын тоо

$$M_e = \frac{n}{2} + 1$$

Ажиллагчдын тоо сондгой бол:

$$M_e = \frac{n + 1}{2}$$

Нэрлэсэн цалин: Хэрэглээний үнийн индексээр засварлагдаагүй, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлдэггүй бөгөөд татвар суутгал хасагдаагүй цалин, хөлс юм.

Нэрлэсэн цалингийн индекс: Тайлант болон суурь хугацаа (жил, улирлын)-ны нэрлэсэн дундаж цалин хөлсний хувиар илэрхийлсэн харьцаа байна.

Бодит цалин: Нэрлэсэн цалингийн хэрэглээний үнийн индексээр засварлагдсан, худалдан авах чадварын өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Бодит цалингийн индекс: Нэрлэсэн цалингийн индексийг, тайлант оны хэрэглээний үнийн индексэд харьцуулж, 100-гаар үржүүлсэн тооцоо байна.

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР: Дэлхийн улс орнууд цалингийн статистикийн мэдээллийг захиргааны мэдээлэл, аж ахуйн нэгж, байгууллага болон өрхөд суурилсан түүвэр судалгааны мэдээлэлд үндэслэн тооцон гаргаж, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллээ тархаадаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас дэлхийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг үнэлэх, хянах болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлого, хөтөлбөрийг дэмжих, зорилгоор анх 1999 онд “Хөдөлмөрийн зах зээлийн түлхүүр үзүүлэлт”-ийг тодорхойлон гаргаж, хамгийн сүүлд 2015 онд шинэчилсэн (KILM 9th edition) билээ.


ОУХБ-ын “Цалин хөлсийг хамгаалах тухай” 1949 оны 95-р конвенцод “Цалин хөлс гэж ажилтныг ажилд авсан тухай амаар болон бичгээр байгуулсан гэрээний дагуу түүний хийж гүйцэтгэсэн, эсхүл хийж гүйцэтгэвэл зохих ажил үйлчилгээнийх нь төлөө ажил олгогчоос үндэсний хууль тогтоомж болон гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр тогтоон олгож буй аливаа мөнгөн урамшуулал буюу ажлын хөлсийг хэлнэ” хэмээн тодорхойлсон.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн Долдугаар бүлгийн 101 дүгээр зүйлийн дагуу цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал, урамшууллаас бүрддэг.

ҮСХ-ноос ОУХБ-ын “Хөдөлмөрийн статистикийн тухай” 1985 оны 160, 170 дугаар Конвенц, Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.2-ын “ё”-д заасны дагуу дундаж цалин, орлогын албан ёсны статистикийн мэдээллийг тооцож байна.

Үндэсний Статистикийн хороо нь 2000-2013 онд ажиллагчдын сарын дундаж цалин хөлсний мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагад суурилсан түүвэр судалгааны үр дүнгээр тооцож байсан. Мэдээллийн эх үүсвэрийг 2014 оноос эхлэн өөрчилж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар/хуучнаар/-ын нийгмийн даатгалын сангийн мэдээлэлд үндэслэн тооцож байна.

Мэдээллийн эх үүсвэр



Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, дундаж цалингийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийсний үндсэн дээр ажиллагчдын сарын дундаж нэрлэсэн болон бодит цалин, медиан цалинг тодорхойлж, улсын хэмжээнд тархаах, худалдан авах чадварын өөрчлөлтийн хандлагыг тодорхойлох, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон хэрэглэгчдийг холбогдох мэдээллээр хангах, цалингийн статистикийн мэдээллийг баяжуулахад судалгааны зорилго оршиж байна.

Дундаж цалингийн статистикийн мэдээллийг тооцон гаргаснаар олон улсын түвшинд харьцуулах боломжийг бүрдүүлж байгаа юм. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотойгоор цалин хөлсний мэдээллийг ашиглах эрэлт, хэрэгцээ, сонирхол нэмэгдэж өргөн хүрээг хамарч байна.

МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ: Цалин, хөлсний мэдээлэл нь тухайн улс орны ажиллагчдын амьдрал, ажлын нөхцөл, амьжиргааны түвшнийг үнэлэхэд чухал үүрэгтэй юм. Ажиллагчдын цалин, хөлс нэмэгдэхэд өрхийн орлого тэр хэмжээгээр нэмэгдэж, ажилгүйдэл тодорхой хэмжээгээр буурдаг. Тиймээс цалин хөлсний бодлого нь аливаа улс орны ард иргэдийн амьдралын баталгааг илэрхийлэх бодлогын салшгүй нэг хэсэг байж, хөгжлийн нэгэн чухал үзүүлэлт болж байдаг.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин хөлсний мэдээллийг дараах задалгаагаар тархааж байна.

- Улсын дундаж, бүс, аймаг, нийслэл, хүйсээр
- Ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр
- Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Ажиллагчдын ажил мэргэжлийн ангилал, хүйсээр

- Бодит цалингийн индекс, 2015=100, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Байгууллагын хариуцлагын хэлбэр, хүйсээр
- Байгууллагын өмчийн хэлбэр, хүйсээр
- Ажиллагчдын цалин хөлсний бүлгээр

Дундаж цалингийн статистикийн мэдээллийг дараах байдлаар нийтэд хүргэж байна. Үүнд:

- ҮСХ-ноос гаргадаг 2, 5, 8, 11 дүгээр сарын бюллетень, жилийн эмхэтгэлд нийтлэх
- Улирал бүр инфографик, хүснэгт хэлбэрээр тархах
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болох www.1212.mn веб сайтад байршуулах

Түүнчлэн www.1212.mn веб сайтаас мэдээллийн арга зүй, аргачлал, агуулга, танилцуулга, хүснэгтийг татан авч ашиглахаас гадна тус веб сайтад байрших мета мэдээллийн сангаас дундаж цалингийн статистикийн мета мэдээллийг үзэх боломжтой.

IV. ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, бүс, аймаг, нийслэл, хүйсээр, мянган төгрөгөөр

Аймаг, нийслэл	2017			2018			2019			2020			2021		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	944.5	1 029.4	860.4	1 002.9	1 100.3	903.3	1 124.3	1 222.6	1 021.3	1 220.6	1 326.2	1 109.6	1 279.4	1 390.1	1 163.1
Баруун бүс	626.3	633.1	620.3	647.7	655.3	640.9	764.0	754.3	772.8	878.3	860.5	894.5	911.5	890.1	931.2
Баян-Өлгий	591.0	607.4	575.3	593.5	610.1	577.3	718.8	722.4	715.3	825.0	812.1	837.4	851.9	832.7	870.0
Говь-Алтай	648.4	643.8	652.4	675.0	667.3	681.5	789.7	766.4	809.5	901.1	870.7	927.3	935.5	899.6	966.8
Завхан	634.8	636.2	633.7	665.8	673.9	659.1	789.2	780.5	796.4	916.6	911.4	920.9	932.8	906.6	954.6
Увс	623.1	623.7	622.5	640.9	636.5	644.7	763.1	738.7	784.5	870.9	848.2	890.6	905.4	876.9	929.5
Ховд	643.2	658.2	629.4	675.8	695.2	657.4	772.9	771.2	774.6	892.8	875.3	910.7	942.9	935.3	951.0
Хангайн бүс	767.8	858.7	692.9	828.4	947.0	731.5	967.9	1 097.4	863.5	1 104.0	1 242.2	991.1	1 157.3	1 290.7	1 048.1
Архангай	593.1	568.8	609.8	620.7	593.3	639.3	741.8	690.8	776.0	859.9	792.3	905.5	890.9	808.2	947.8
Баянхонгор	623.5	608.2	634.5	656.5	647.9	662.6	776.2	748.4	795.7	863.3	833.5	884.9	912.0	861.7	948.7
Булган	638.8	628.4	647.0	652.1	638.8	663.1	767.8	743.2	787.0	857.4	828.3	879.9	902.2	864.6	932.1
Орхон	1 061.9	1 283.4	837.6	1 216.4	1 508.0	925.0	1 417.6	1 769.3	1 070.2	1 628.3	2 009.7	1 239.8	1 723.5	2 112.3	1 327.8
Өвөрхангай	631.5	605.4	650.9	653.1	629.2	671.0	777.5	742.1	803.8	891.0	846.5	924.0	919.7	858.4	964.1
Хөвсгөл	605.7	602.6	608.0	619.9	621.4	618.8	736.3	725.3	744.6	853.3	829.4	871.5	878.8	845.9	903.9
Төвийн бүс	774.5	850.4	697.5	829.1	924.8	729.8	960.5	1 067.1	849.0	1 088.7	1 199.0	972.4	1 158.7	1 272.5	1 033.2
Говьсүмбэр	873.5	988.3	756.8	918.0	1 038.9	794.3	1 052.8	1 183.4	922.2	1 177.0	1 316.8	1 039.7	1 271.0	1 424.3	1 121.0
Дархан-Уул	805.2	902.2	705.0	845.1	.	737.3	961.8	1 077.8	843.1	1 078.0	1 200.8	952.9	1 151.1	1 281.4	1 013.7
Дорноговь	839.1	933.9	738.6	895.5	1 010.0	773.0	1 014.7	1 129.5	889.7	1 131.9	1 253.2	1 004.8	1 213.8	1 360.2	1 064.3
Дундговь	642.5	646.2	639.9	656.3	649.2	661.4	799.9	783.2	811.7	919.1	895.4	935.7	970.3	944.1	989.1
Өмнөговь	857.7	967.1	718.0	933.9	1 071.4	753.2	1 080.4	1 238.3	857.1	1 220.3	1 382.1	980.3	1 264.3	1 380.6	1 062.5
Сэлэнгэ	710.8	746.2	676.8	789.0	857.5	719.4	921.8	1 001.2	843.4	1 043.0	1 115.6	970.8	1 130.9	1 244.6	1 019.4
Төв	656.1	654.1	657.9	671.0	673.4	669.0	788.4	770.8	803.2	946.7	937.9	954.3	1 000.5	997.0	1 003.6
Зүүн бүс	705.6	737.2	677.3	728.2	778.5	681.9	856.7	899.5	816.6	987.0	1 048.5	930.1	1 042.3	1 103.7	984.5
Дорнод	778.9	811.5	748.7	780.1	836.3	725.6	894.5	931.7	857.9	1 009.5	1 064.5	955.5	1 070.0	1 125.9	1 015.2
Сүхбаатар	658.3	688.1	630.3	690.1	724.7	657.8	797.8	826.8	770.4	910.8	941.8	883.7	957.2	980.1	936.5
Хэнтий	652.7	681.6	628.3	694.7	746.8	649.7	854.9	914.7	802.5	1 015.3	1 105.4	934.5	1 071.7	1 165.9	984.3
Улаанбаатар	1 062.4	1 152.3	969.2	1 119.7	1 217.2	1 014.6	1 232.2	1 329.1	1 124.3	1 312.6	1 419.6	1 193.4	1 370.7	1 486.2	1 243.5

2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр

Ажиллагчдын тооны бүлэг	2017			2018			2019			2020			2021		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	944.5	1 029.4	860.4	1 002.9	1 100.3	903.3	1 124.3	1 222.6	1 021.3	1 220.6	1 326.2	1 109.6	1 279.4	1 390.1	1 163.1
1-9	628.2	646.5	612.6	646.8	667.4	628.8	730.6	753.7	710.0	827.5	846.4	809.9	861.2	882.6	840.6
10-49	743.9	765.0	725.8	761.5	790.1	736.3	872.9	891.8	856.0	967.4	981.2	954.9	1 044.5	1 047.9	1 041.4
50-99	851.9	883.1	824.5	891.8	948.4	840.0	977.2	1 018.4	937.5	1 076.6	1 119.5	1 035.7	1 135.7	1 206.0	1 069.7
100-199	923.6	977.3	867.7	993.4	1 051.8	932.7	1 079.5	1 127.0	1 030.6	1 227.6	1 296.6	1 155.3	1 279.4	1 348.6	1 206.6
200, түүнээс дээш	1 295.8	1 428.2	1 133.1	1 387.4	1 524.7	1 211.5	1 556.9	1 702.9	1 363.9	1 660.3	1 834.8	1 431.3	1 713.0	1 906.9	1 465.1

3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган төгрөгөөр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2017	2018	2019	2020	2021
Улсын дундаж	944.5	1 002.9	1 124.3	1 220.6	1 279.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	681.5	736.4	833.1	949.6	1 002.8
Уул уурхай, олборлолт	2 119.1	2 221.4	2 590.0	2 877.4	2 997.8
Боловсруулах үйлдвэрлэл	1 088.2	1 150.8	1 171.1	1 163.9	1 227.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 334.2	1 403.3	1 452.0	1 558.9	1 603.3
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	678.0	726.8	830.2	977.1	1 019.3
Барилга	852.3	1 032.7	1 161.9	1 273.9	1 227.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	793.0	818.6	904.8	1 001.7	1 063.1
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1 022.5	1 046.8	1 117.0	1 203.4	1 287.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	585.0	621.4	691.5	730.2	801.7
Мэдээлэл, холбоо	865.8	979.0	1 086.6	1 196.8	1 317.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1 131.6	1 160.6	1 343.1	1 453.7	1 515.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	870.1	1 022.8	1 197.7	1 378.3	1 401.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1 569.7	1 546.9	1 580.6	1 648.3	1 665.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	760.3	829.4	995.8	1 084.4	1 162.5
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	832.2	898.0	1 030.0	1 093.2	1 140.7
Боловсрол	720.8	760.2	903.3	1 013.0	1 045.2
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	767.1	800.4	940.7	1 108.6	1 277.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	605.2	624.2	738.1	844.0	873.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	751.1	809.8	910.7	1 019.1	1 098.0
Хүн хөлслөн ажиллүүлдаг өрхийн үйл ажиллагаа	594.4	672.9	799.3	906.8	1 042.9
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 710.0	1 479.9	1 778.0	1 822.7	1 994.1

ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин - 2021

4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, мянган төгрөгөөр

Ажил, мэргэжлийн ангилал	2017			2018			2019			2020			2021		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	944.5	1 029.4	860.4	1 002.9	1 100.3	903.3	1 124.3	1 222.6	1 021.3	1 220.6	1 326.2	1 109.6	1 279.4	1 390.1	1 163.1
Менежер	1 073.9	1 132.9	1 009.9	1 097.8	1 161.1	1 027.4	1 201.0	1 258.9	1 137.8	1 366.8	1 418.1	1 308.9	1 385.8	1 453.9	1 309.0
Мэргэжилтэн	1 053.7	1 276.2	945.4	1 138.2	1 392.0	1 010.5	1 344.9	1 611.1	1 211.5	1 391.8	1 603.1	1 283.0	1 480.2	1 719.4	1 358.3
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	1 083.1	1 149.7	998.9	1 193.6	1 308.5	1 046.1	1 350.8	1 483.2	1 174.1	1 470.6	1 592.2	1 303.4	1 541.7	1 675.0	1 372.0
Контор, үйлчилгээний ажилтан	915.9	1 067.5	830.1	967.9	1 129.0	875.1	1 099.2	1 299.4	981.0	1 235.4	1 466.3	1 092.2	1 298.1	1 578.0	1 130.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	671.8	771.7	599.0	693.5	783.0	627.8	776.6	873.9	704.2	864.6	982.2	777.4	913.7	1 041.9	819.8
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	511.7	498.0	538.2	518.1	505.7	539.0	633.9	623.9	649.0	701.3	690.2	718.3	752.5	734.7	780.4
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	928.3	1 003.5	758.4	989.5	1 082.9	786.1	1 250.7	1 303.6	1 140.0	1 257.1	1 362.8	1 019.7	1 329.8	1 419.6	1 123.6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	1 150.4	1 142.1	1 202.3	1 191.1	1 179.4	1 268.1	1 296.9	1 284.4	1 388.1	1 419.8	1 415.6	1 451.3	1 493.2	1 492.1	1 501.8
Энгийн ажил, мэргэжил	661.3	706.2	615.9	714.2	771.7	655.9	821.9	896.9	741.8	939.8	1 020.9	856.7	997.5	1 073.0	918.1
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	997.1	1 002.7	980.2	1 056.7	1 072.6	1 007.1	1 234.6	1 261.2	1 150.5	1 327.9	1 355.7	1 246.5	1 359.5	1 375.8	1 306.0

5. БОДИТ ЦАЛИНГИЙН ИНДЕКС, 2015=100, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2017 хувь	2018	2019	2020	2021
Улсын дундаж	111.2	110.6	115.5	120.9	118.3
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	100.7	101.9	107.4	118.1	116.4
Уул уурхай, олборлолт	106.4	104.4	113.5	121.5	118.2
Боловсруулах үйлдвэрлэл	134.5	133.1	126.3	121.0	119.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	111.6	109.9	106.0	109.7	105.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	101.6	102.0	108.6	123.2	120.0
Барилга	122.4	138.8	145.6	153.9	138.4
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	108.5	104.9	108.0	115.3	114.3
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	110.0	105.4	104.8	108.9	108.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	105.5	104.9	108.8	110.8	113.5
Мэдээлэл, холбоо	103.2	109.2	113.0	120.0	123.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	102.6	98.5	106.2	110.9	107.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	102.1	112.4	122.6	136.1	129.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	130.5	120.4	114.6	115.3	108.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	109.2	111.6	124.8	131.1	131.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	100.4	101.4	108.4	110.9	108.1
Боловсрол	93.3	92.1	102.0	110.3	106.2
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	94.0	91.8	100.6	114.3	123.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	92.9	89.7	98.9	109.0	105.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	99.0	99.9	104.7	113.0	113.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	100.8	106.8	118.2	129.3	138.9
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	111.4	90.3	101.1	99.9	102.0

ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин - 2021

6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, байгууллагын хариуцлагын хэлбэр, хүйсээр, мянган төгрөгөөр

Хариуцлагын хэлбэр	2017			2018			2019			2020			2021		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	944.5	1 029.4	860.4	1 002.9	1 100.3	903.3	1 124.3	1 222.6	1 021.3	1 220.6	1 326.2	1 109.6	1 279.4	1 390.1	1 163.1
Хувьцаат компани	1 090.9	1 211.4	942.0	1 150.8	1 272.2	992.8	1 258.2	1 388.5	1 084.1	1 382.8	1 527.2	1 187.4	1 421.9	1 560.3	1 231.4
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1 045.8	1 108.2	966.6	1 110.2	1 185.5	1 010.9	1 216.6	1 294.8	1 109.5	1 279.8	1 373.5	1 149.5	1 338.9	1 444.2	1 194.2
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	679.3	647.8	689.2	702.9	655.0	717.5	803.6	792.3	807.0	1 034.1	892.9	1 074.9	1 372.5	1 044.7	1 471.0
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	738.6	501.1	817.0	523.6	434.2	562.8	609.9	531.0	646.4	794.3	701.5	828.8	955.3	756.1	1 036.8
Хоршоо	462.0	411.6	507.0	483.7	436.0	526.1	577.2	528.8	620.9	654.6	612.2	692.4	666.7	614.7	714.9
Төрийн өмчит үйлдвэрийн газар	1 118.3	1 228.8	959.6	1 211.1	1 333.6	1 032.2	1 352.7	1 488.1	1 161.3	1 546.5	1 700.0	1 319.3	1 679.3	1 849.7	1 421.9
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	697.5	719.4	657.6	752.4	779.3	703.4	851.0	870.4	814.9	960.6	987.4	909.1	999.6	1 036.2	930.5
Төсөвт байгууллага	743.0	766.5	730.7	772.8	796.4	760.9	917.2	927.9	911.9	1 053.4	1 068.4	1 046.0	1 099.4	1 107.0	1 095.7
Төрийн бус байгууллага	755.6	752.7	757.3	794.1	793.0	794.8	888.9	900.5	882.0	999.4	1 030.6	980.8	1 075.0	1 091.7	1 065.0
Бусад (хувийн цэцэрлэг, сургууль гэх мэт)	1 125.4	1 237.7	1 042.3	1 176.6	1 315.4	1 072.9	1 288.6	1 452.1	1 167.2	1 382.4	1 463.7	1 313.5	1 462.4	1 566.5	1 375.1

7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, байгууллагын өмчийн хэлбэрээр, мянган төгрөгөөр

Өмчийн хэлбэр	2017	2018	2019	2020	2021
Улсын дундаж	944.5	1 002.9	1 124.3	1 220.6	1 279.4
Төрийн					
Өмчийн	884.0	935.1	1 083.5	1 221.0	1 275.5
Өмчийн оролцоотой	975.7	1 075.0	1 199.0	1 422.7	1 516.0
Хамтарсан	2 677.8	2 937.8	3 339.8	3 688.1	3 874.2
Орон нутгийн					
Өмчийн	671.8	714.3	824.4	943.4	969.0
Өмчийн оролцоотой	707.4	753.9	858.0	1 080.5	1 224.6
Хамтарсан	696.1	743.1	817.4	898.5	970.2
Хувийн					
Монгол Улсын	733.0	796.6	888.5	977.8	1 058.9
Гадаадтай хамтарсан	947.9	1 056.4	1 253.0	1 377.9	1 372.8
Гадаад улсын	2 309.4	2 308.3	2 244.2	2 141.7	2 177.6

8. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр¹, дүнд эзлэх хувиар

Цалин хөлсний бүлгээр	2017		2018	
	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь
Бүгд	725 430	100.0	774 607	100.0
240 000 төгрөг хүртэл	57 946	8.0	59 020	7.6
240 001-300 000	43 371	6.0	40 913	5.3
300 001-500 000	133 438	18.4	130 699	16.9
500 001-700 000	150 591	20.8	153 071	19.8
700 001-900 000	122 609	16.9	130 155	16.8
900 001-1 100 000	74 392	10.2	85 892	11.1
1 100 001- 1 300 000	42 266	5.8	48 691	6.3
1 300 001- 1 500 000	25 816	3.6	32 233	4.2
1 500 001 төгрөгөөс дээш	75 001	10.3	93 933	12.1

¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сард 240000 төгрөг (хоёр зуун дөчин мянган төгрөг) байхаар шинэчлэн тогтоосон.

8.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр¹, дүнд эзлэх хувиар

Цалин хөлсний бүлгээр	2019	
	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь
Бүгд	813 744	100.0
320 000 төгрөг хүртэл	80 668	9.9
320 001-500 000	116 440	14.3
500 001-700 000	141 691	17.4
700 001-900 000	125 173	15.4
900 001-1 100 000	104 834	12.9
1 100 001- 1 300 000	71 827	8.8
1 300 001- 1 500 000	45 658	5.6
1 500 001 төгрөгөөс дээш	127 453	15.7

¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сард 320000 төгрөг (гурван зуун хорин мянган төгрөг) байхаар шинэчлэн тогтоосон.

8.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД, цалин хөлсний бүлгээр¹, дүнд эзлэх хувиар

Цалин хөлсний бүлгээр	2020		2021	
	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь	Ажиллагчид	Дүнд эзлэх хувь
Бүгд	808 010	100.0	840 140	100.0
420 000 төгрөг хүртэл	96 439	11.9	96 390	11.5
420 001-700 000	188 299	23.3	176 739	21.0
700 001-900 000	118 929	14.7	119 249	14.2
900 001-1 100 000	106 487	13.2	108 983	13.0
1 100 001- 1 300 000	78 424	9.7	81 798	9.7
1 300 001- 1 500 000	58 802	7.3	63 675	7.6
1 500 001- 2 000 000	75 075	9.3	88 326	10.5
2 000 001- 2 500 000	32 931	4.1	40 514	4.8
2 500 001 төгрөгөөс дээш	52 624	6.5	64 466	7.7

¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сард 420000 төгрөг (дөрвөн зуун хорин мянган төгрөг) байхаар шинэчлэн тогтоосон.

--- оОо ---